



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Байгаль орчны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр

Утас: 89275858

Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
5.1 Төлбөрийн акт.....	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА  
Г.БАТБАЯР ТАНАА

2025 о.д.дс № 88

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Байгаль орчны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Дархан-Уул аймагт 4 байршилд 205.85 га газар техникийн нөхөн сэргээлтийн ажил, хонгор сумын хар бэлчрийн ар булгийг тохижуулсан, мөн Дархан-Уул аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах 2025-2035 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө” боловсруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 470,821.9 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 64.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Байгаль орчны газар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 56 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.96 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,299,036.00</b>	<b>186,757,036.00</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,361,300.00</b>	<b>6,810,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	3,361,300.00	6,810,000.00
	Найдваргүй авлагын хасагдуулга		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>41,937,736.00</b>	<b>179,947,036.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	-
354	<b>Хангамжийн материал</b>	<b>41,937,736.00</b>	<b>179,947,036.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,919,350.00	2,927,750.00
35420	Аж ахуйн материал	30,129,386.00	38,655,286.00
3543	Сэлбэг хэрэгсэл	3,840,000.00	4,635,000.00
35470	Бусад хангамжийн материал	6,049,000.00	133,729,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,496,452.22</b>	<b>207,068,251.39</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>148,496,452.22</b>	<b>207,068,251.39</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>127,034,436.12</b>	<b>132,962,579.43</b>
39217	Тээврийн хэрэгсэл	22,300,000.00	4,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,015,624.70)	(2,553,124.62)
39205	Машин тоног төхөөрөмж	46,958,520.00	56,321,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,459,617.91)	(17,248,277.36)
39207	Тавилга, эд хогшил	27,277,822.02	26,729,886.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,027,017.41)	(15,733,818.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	95,963,106.00	95,963,106.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,962,751.88)	(14,816,293.08)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>21,462,016.10</b>	<b>74,105,671.96</b>
39301	Программ хангамж	4,539,353.00	4,539,353.00
39302	Хасагдуулга	(3,514,836.90)	(4,197,847.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,500,000.00	83,335,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,062,500.00)	(9,570,833.34)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>193,795,488.22</b>	<b>393,825,287.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,361,300.00</b>	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,700,100.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	661,200.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>190,434,188.22</b>	<b>393,825,287.39</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>190,434,188.22</b>	<b>393,825,287.39</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	118,548,542.56	118,548,542.56
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>71,707,344.17</b>	<b>275,098,443.34</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	71,707,344.17	72,907,444.17
51220	Тайлант үеийн үр дүн		202,190,999.17
51300	Дахин үнэлгээний зөрүү	178,301.49	178,301.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>193,795,488.22</b>	<b>393,825,287.39</b>

ХТ054305-9022553

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>587,472,586.00</b>	<b>1,314,148,700.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>86,871,586.00</b>	<b>16,191,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>86,871,586.00</b>	<b>16,191,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	<b>1,276,400.00</b>	<b>12,288,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,276,400.00	12,218,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	85,525,186.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	70,000.00	3,903,000.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>500,601,000.00</b>	<b>1,297,957,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,000,000.00</b>	<b>93,600,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		93,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,000,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>490,601,000.00</b>	<b>1,204,357,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	490,601,000.00	1,204,357,700.00
<b>2</b>	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>554,360,818.33</b>	<b>1,111,957,700.83</b>
<b>21</b>	<b>Урсгал зардал</b>	<b>554,360,818.33</b>	<b>1,111,957,700.83</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>547,312,512.61</b>	<b>1,062,873,771.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>285,472,374.26</b>	<b>470,821,890.59</b>
210101	Үндсэн цалин	153,421,566.08	242,692,154.66
210102	Нэмэгдэл цалин	83,971,485.69	183,957,228.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,117,668.07	17,435,185.50
210104	Урамшуулал	30,961,654.42	26,737,322.00
210105	Гэрээтийн цалин		
<b>2102</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>36,107,468.02</b>	<b>58,022,506.17</b>
210201	Тэтгэврийн даатгалын	24,665,277.84	39,818,537.51
210202	тэтгэмжийн даатгалын	2,901,797.54	4,650,708.76
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,277,438.07	2,562,395.59
210204	Ажилгүйдлийн даатгалын	569,359.48	2,198,172.93
210205	ЭМ-ийн даатгалын	5,693,595.09	8,792,691.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,599,600.00</b>	<b>13,551,600.00</b>

ХТ0543080022839

210301	Гэрэл цахилгааны зардал		
210302	Түлш, халаалтын зардал		
210303	Цэвэр бохир усны зардал		
210304	Байрны түрээс	13,599,600.00	13,551,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,960,155.40</b>	<b>19,603,873.56</b>
210401	Бичиг хэргийн зардал	3,792,070.00	3,311,350.00
210404	Тээвэр шатахуун	9,623,540.00	8,187,960.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,511,532.00	1,447,312.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	578,000.00	4,984,250.00
210408	Бараа материал акталсны зардал	11,455,013.40	1,673,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,200,100.00</b>	<b>2,760,000.00</b>
210601	Багаж техник, хэрэгсэл	1,200,100.00	-
210604	Урсгал засварын зардал		2,760,000.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	<b>4,236,200.00</b>	<b>1,886,400.00</b>
210702	Дотоодын томилолт	4,236,200.00	1,886,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>31,229,290.00</b>	<b>88,366,980.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	29,476,310.00	86,790,000.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	954,200.00	954,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,780.00	95,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	11,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	681,000.00	516,000.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>148,507,324.93</b>	<b>407,860,520.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	129,525,300.00	376,064,420.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	277,000.00	335,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,705,024.93	31,461,100.83
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>7,048,305.72</b>	<b>49,083,929.68</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,886,000.00</b>	<b>34,319,876.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,886,000.00	2,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		32,319,876.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,162,305.72</b>	<b>14,764,053.68</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,162,305.72	14,764,053.68
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>33,111,767.67</b>	<b>202,190,999.17</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		-




225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал		
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>		-
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>33,111,767.67</b>	<b>202,190,999.17</b>


### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>500,601,000.00</b>	<b>1,301,389,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>70,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>70,000.00</b>
120002	Хүүгийн орлого		
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>70,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>500,601,000.00</b>	<b>1,301,319,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,000,000.00</b>	<b>96,961,300.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	-	93,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,000,000.00	3,361,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>490,601,000.00</b>	<b>1,204,357,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	490,601,000.00	1,204,357,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>495,801,100.00</b>	<b>1,223,574,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>495,801,100.00</b>	<b>1,223,574,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>485,391,494.28</b>	<b>1,167,680,170.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>285,472,374.26</b>	<b>470,821,890.59</b>
210101	Үндсэн цалин	153,421,566.08	242,692,154.66
210102	Нэмэгдэл	83,971,485.69	183,957,228.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,117,668.07	17,435,185.50
210104	Урамшуулал	30,961,654.42	26,737,322.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,107,468.02</b>	<b>58,022,506.17</b>
210201	Тэтгэврийн даатгалын	24,665,277.84	39,818,537.51

210202	Тэтгэмжийн даатгалын	2,901,797.54	4,650,708.76
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,277,438.07	2,562,395.59
210204	Ажилгүйдлийн даатгалын	569,359.48	2,198,172.93
210205	Эрүүл мэндийн даатгалын	5,693,595.09	8,792,691.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,599,600.00</b>	<b>13,551,600.00</b>
210304	Байрны түрээс	13,599,600.00	13,551,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>14,914,972.00</b>	<b>13,236,973.56</b>
210401	Бичиг хэргийн зардал	2,588,700.00	2,036,150.00
210404	Тээвэр шатахуун	9,623,540.00	8,187,960.70
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл технологийн үйлчилгээ	1,511,532.00	1,452,812.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,191,200.00	1,560,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,420,000.00</b>	<b>4,880,000.00</b>
210501	Эм		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас	1,420,000.00	4,880,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>1,470,000.00</b>	<b>3,700,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	1,470,000.00	-
210604	Урсгал засвар		3,700,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,575,000.00</b>	<b>2,547,600.00</b>
210702	Дотоодын томилолт	3,575,000.00	2,547,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,752,980.00</b>	<b>88,366,980.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		86,790,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	954,200.00	954,200.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,780.00	95,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	11,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	681,000.00	516,000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,079,100.00</b>	<b>512,552,620.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	126,701,300.00	512,217,620.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	377,800.00	335,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,409,605.72</b>	<b>55,893,929.68</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,886,000.00</b>	<b>34,319,876.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,886,000.00	2,000,000.00



213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг		32,319,876.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213304	Хөрөнгийн		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>8,523,605.72</b>	<b>21,574,053.68</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,162,305.72	14,764,053.68
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,361,300.00	6,810,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	-	-
<b>2220</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
222001	Тоног төхөөрөмж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
225107	Тоног төхөөрөмж		
225108	Бусад хөрөнгө		
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>4,799,900.00</b>	<b>77,814,900.00</b>
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<b>4</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>		
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>4,799,900.00</b>	<b>77,814,900.00</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>4,799,900.00</b>	<b>77,814,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,799,900.00</b>	<b>77,814,900.00</b>
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө	4,799,900.00	77,814,900.00
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,799,900.00)</b>	<b>(77,814,900.00)</b>
<b>7</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>118,548,542.56</b>	<b>178,301.49</b>	<b>38,595,576.50</b>	<b>157,322,420.55</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,548,542.56	178,301.49	125,654,986.37	<b>244,381,830.42</b>
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			33,111,767.67	<b>33,111,767.67</b>
<b>2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>118,548,542.56</b>	<b>178,301.49</b>	<b>71,707,344.17</b>	<b>190,434,188.22</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт			1,200,100.00	<b>1,200,100.00</b>
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			202,190,999.17	<b>202,190,999.17</b>
<b>2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>118,548,542.56</b>	<b>178,301.49</b>	<b>275,098,443.34</b>	<b>393,825,287.39</b>




## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,362,083,200.00	1,189,593,646.32	(172,489,553.68)	87.3
21	Урсгал зардлын дүн	1,362,083,200.00	1,189,593,646.32	(172,489,553.68)	87.3
210	Бараа үйлчилгээний зардал	1,327,432,700.00	1,155,273,770.32	(172,158,929.68)	87.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	481,536,500.00	470,821,890.59	(10,714,609.41)	97.8
210101	Үндсэн цалин	257,765,600.00	242,692,154.66	(15,073,445.34)	94.2
210102	Нэмэгдэл	178,813,700.00	183,957,228.43	5,143,528.43	102.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,106,200.00	17,435,185.50	(671,014.50)	96.3
210104	Урамшуулал	26,851,000.00	26,737,322.00	(113,678.00)	99.6
210105	Гэрээт ажлын хөлс			-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,192,100.00	58,022,506.17	(2,169,593.83)	96.4
210201	Тэтгэврийн даатгал	40,930,600.00	39,818,537.51	(1,112,062.49)	97.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,815,400.00	4,650,708.76	(164,691.24)	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,407,700.00	2,562,395.59	154,695.59	106.4
210204	Ажилгүйдлийн даатгал	2,407,700.00	2,198,172.93	(209,527.07)	91.3
210205	ЭМД-ын хураамж+В21	9,630,700.00	8,792,691.38	(838,008.62)	91.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,725,500.00	13,551,600.00	(173,900.00)	98.7
210304	Байрны түрээсийн зардал	13,725,500.00	13,551,600.00	(173,900.00)	98.7
2104	Хангамж, бараа материалын зардал	18,379,700.00	13,166,973.56	(5,212,726.44)	71.6
210401	Бичиг хэрэг	1,967,300.00	1,966,150.00	(1,150.00)	99.9
210402	Тээвэр шатахуун	13,244,700.00	8,187,960.70	(5,056,739.30)	61.8
210403	Шуудан холбоо, интернет төлбөр	1,603,100.00	1,452,812.86	(150,287.14)	90.6
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,564,600.00	1,560,050.00	(4,550.00)	99.7
2105	Нормативт зардал	5,325,000.00	4,880,000.00	(445,000.00)	91.6
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	5,325,000.00	4,880,000.00	(445,000.00)	91.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,080,000.00	8,079,800.00	(200.00)	100.0
210601	Багаж хэрэгсэл	4,380,000.00	4,379,800.00	(200.00)	100.0
210604	Урсгал засвар	3,700,000.00	3,700,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,934,000.00	1,886,400.00	(47,600.00)	97.5
210702	Дотоод томилолт	1,934,000.00	1,886,400.00	(47,600.00)	97.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,236,300.00	1,576,980.00	(659,320.00)	70.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	954,200.00	954,200.00	-	100.0

210803	Даатгалын үйлчилгээ	109,600.00		(109,600.00)	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	95,780.00	(164,220.00)	36.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	11,000.00	(77,000.00)	12.5
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	747,000.00	516,000.00	(231,000.00)	69.1
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,500.00			
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<b>736,023,600.00</b>	<b>583,287,620.00</b>	(152,735,980.00)	79.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	735,413,200.00	582,952,620.00	(152,460,580.00)	79.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	610,400.00	335,000.00	(275,400.00)	54.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>34,650,500.00</b>	<b>34,319,876.00</b>	(330,624.00)	99.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,022,600.00	2,000,000.00	(22,600.00)	98.9
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	32,627,900.00	32,319,876.00		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<b>1,362,083,200.00</b>	<b>1,189,593,646.32</b>	(172,489,553.68)	87.3
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	<b>1,362,083,200.00</b>	<b>1,189,593,646.32</b>	(172,489,553.68)	87.34
132001	Орон нутгийн төсвөөс	1,052,631,100.00	1,189,593,646.32	136,962,546.32	113.01
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/			-	
015	Төрийн өмчит ЕБС байгууллага			-	
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15.00	15.00	-	100.0
028	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	11.00	11.00	-	100.0
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ГҮ/	4.00	4.00	-	100.0



## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	96,961,300.00	96,961,300.00	-	100%
21	Урсгал зардлын дүн	96,961,300.00	96,961,300.00	-	100%
210	Бараа үйлчилгээний зардал	90,151,300.00	90,151,300.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,100.00	1,200,100.00	-	100%
210601	Багаж хэрэгсэл	1,200,100.00	1,200,100.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	661,200.00	661,200.00	-	100%
210702	Дотоод томилолт	661,200.00	661,200.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	86,790,000.00	86,790,000.00	-	100%
210801	Бараа үйлчилгээний бусад зардал	86,790,000.00	86,790,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,810,000.00	6,810,000.00	-	100%
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,810,000.00	6,810,000.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>96,961,300.00</b>	<b>96,961,300.00</b>	-	<b>100%</b>
	Нэмэлт санхүүжилтийн орлого	<b>96,961,300.00</b>	<b>96,961,300.00</b>	-	<b>100%</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	93,600,000.00	93,600,000.00		100%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,361,300.00	3,361,300.00		100%



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Байгаль орчны талаар явуулж буй төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлох, мэдээллийн сан бүрдүүлэх, ус цаг уур орчны шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчны сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээ авах зэрэг ажлыг эрхлэн гүйцэтгэх замаар экологийн аюулгүй байдлыг хангахад тус албаны эрхэм зорилго оршино.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ болон Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Журам батлах тухай”, 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 2022 оны 192 дугаар тогтоол “ үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоол “ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, Иргэний тухай хууль, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 200,029.8 мянган төгрөгөөр буюу 103.2 өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,361.30	6,810.00	3,448.70
Бараа материал	41,937.70	179,947.00	138,009.30
Үндсэн хөрөнгө	148,496.50	207,068.30	58,571.80
<b>Нийт хөрөнгө</b>	<b>193,795.50</b>	<b>393,825.30</b>	<b>200,029.80</b>
Өр төлбөр	3,361.30		(3,361.30)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	190,434.20	393,825.30	203,391.10
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>193,795.50</b>	<b>393,825.30</b>	<b>200,029.80</b>

Авлага дансны үлдэгдэл 6,810.0 мянган төгрөг болж 3,448.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлага 3,361.3 мянган төгрөгийг барагдуулж, нэмэлт санхүүжилтийн Ойн газраас Хонгор сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулсан бөгөөд 6,810.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 179,947.0 мянган төгрөг болж 138,009.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 169,618.8 мянган төгрөгийн мод худалдан авсан% Силкат ХХК-аас Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 3,903.0 мянган төгрөгөөр аж, ахуйн материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, үйл ажиллагаанд 33,839.5 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан, Даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/37 тоот тушаалаар 1,673.0 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хасаж акталж устгасан зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 207,068.2 мянган төгрөг болж 58,571.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18,379.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 600.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 58,835.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот албан бичгийг үндэслэн 19,629.1 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээгээр 12,218.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэж, Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 2,145.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 608.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 31-ний дугаар 29 тогтоолоор 18,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж /УАЗ-469 машин/ акталж данс бүртгэлээс хасаж, тайлант онд 31,461.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 393,825.3 мянган төгрөг болж 203,391.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 796,068.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, 1,052,631.1 мянган төгрөгөөр батлагдаж, 2023 оны нөхөн сэргээх арга хэмжээний зардал 309,452.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн дунд хугацааны хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,052,631.1 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 309,452.1 мянган төгрөг нийт 1,362,083.2 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,204,357.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,189,593.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 14,764.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,189,593.6 мянган төгрөг буюу 87.34 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 14,764.0 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71413-Байгаль орчин, хамгаалах нөхөн сэргээх</b>	<b>1,362,083.20</b>	<b>1,189,593.64</b>	<b>(172,489.56)</b>	<b>87.34</b>
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	578,354.00	558,829.55	<b>(19,524.45)</b>	<b>96.62</b>
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	34,650.50	34,319.87	<b>(330.63)</b>	<b>99.05</b>
1.3	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	13,725.50	13,551.60	<b>(173.90)</b>	<b>98.73</b>
1.4	81701-Байгаль орчиныг хамгаалах нөхөн сэргээх	735,353.20	582,892.62	<b>(152,460.58)</b>	<b>79.27</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах

бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 12 ажилтан, үйлчлэх 2 ажилтан буюу нийт 15 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 86,790.0 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 500,962.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 93,600.0 мянган төгрөгийг хүлээн авч, 6,810.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлсэн байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 554,360.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,543.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 1,320.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	1,320.0	1	1,320.0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,320.0</b>	<b>1</b>	<b>1,320.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>1</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил						Үүнээс					
							Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
-												
<b>Дүн</b>												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Тус байгууллагын Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>